



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А-327

Улаанбаатар хот

Журам, аргачлал батлах тухай

“Агаарын тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Агаарын чанарыг агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”-ыг 1 дүгээр, “Агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, эрүүл мэндийн зөвлөгөө”-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/, Цаг уур, орчны шинжилгээний газар /С.Энхтүвшин/-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.


4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Журам аргачлал батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-53 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



САЙД

С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2014 оны 29 дүгээр сарын 17-ны өдрийн
А-32.1 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



АГААРЫН ЧАНАРЫГ АГААРЫН ЧАНАРЫН ИНДЕКСЭЭР ҮНЭЛЭХ, МЭДЭЭЛЭХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 “Агаарын чанарыг агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам” нь “Агаарын тухай” хууль, “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS4585:2007 стандартыг /стандартад өөрчлөлт орсон тохиолдолд сүүлчийн албан ёсны стандартыг хэрэглэнэ/ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.2 Агаарын чанарын индекс гэж хот суурин газрын хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын тухайн үеийн агууламжийг түүний стандартад заагдсан хүлцэх хэм хэмжээнд харьцуулсан тоон үзүүлэлтийг хэлнэ.

1.3 Агаарын чанарыг индексээр үнэлж, мэдээлэх нь хот, суурин газрын хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох, агаарын бохирдлоос өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар олон нийтэд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, агаарын бохирдлоос сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг өгнө.

1.4 Агаарын чанарын индексийг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодисоор тооцно. Үүнд:

- а) хүхрийн давхар исэл (SO_2);
- б) азотын давхар исэл (NO_2);
- в) 10 мкм-ээс бага хэмжээтэй том ширхэглэгт тоосонцор (PM_{10});
- г) 2.5 мкм-ээс бага хэмжээтэй нарийн ширхэглэгт тоосонцор ($PM_{2.5}$);
- д) нүүрстөрөгчийн дутуу исэл (CO);
- е) озон (O_3)

Хоёр. Агаарын чанарын индексийн ангилал ба үнэлгээ

2.1. Агаарын чанарыг Агаарын чанарын индексээр 6 түвшинд ангилах бөгөөд түвшин тус бүрт харгалзах индексийн тоон үзүүлэлт, өнгөт тэмдэглэгээ, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг хураангуй байдлаар Хүснэгт 1-д харуулав.

**Агаарын чанарын индекс,
хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл**

Хүснэгт 1

Агаарын чанарын индекс	Агаарын чанарын ангилал	Тэмдэглэгээ (өнгөөр)	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0 - 50	Цэвэр	Ногоон	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Шар	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал: озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101 – 250	Бага зэргийн бохирдолтой	Улбар шар	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251 – 400	Дунд зэргийн бохирдолтой	Ягаан	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401- 500	Их бохирдолтой	Хүрэн	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл илэрнэ.
501 <	Маш их бохирдолтой	Улаан	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.

2.3. Агаарын чанарын индекс нь 100 ба түүнээс бага байвал агаарын чанар стандартын шаардлага хангаж байна, 101-ээс их байвал агаарын чанар стандартын шаардлага хангахгүй байна гэж үзнэ.

Гурав. Агаарын чанарын индексийг тооцох арга

3.1 Агаарын чанарын индексийг тооцохдоо агаар дахь бохирдуулах бодис тус бүрд тооцох ба бохирдуулах бодисын агууламжийг тухайн бохирдуулах бодисын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнд харьцуулж дараах томъёог ашиглан тооцно.

$$АЧИ = \frac{ББА}{XXX} * 100$$

АЧИ - агаарын чанарын индекс

ББА – агаар дахь бохирдуулах бодисын агууламж

XXX – Агаарын чанарын стандарт дахь тухайн бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ

3.2. Бохирдуулах бодис тус бүрт тооцсон индексийн хамгийн өндөр тоон үзүүлэлтээр тухайн үеийн агаарын чанарыг агаарын чанарын индексийн ерөнхий үнэлгээгээр тогтооно. Жишээлбэл: Агаарын чанарыг агаарын чанарын индексээр тооцоход хүхрийн давхар ислийн индекс 110, азотын давхар ислийн индекс 95, том ширхэглэгт тоосонцор 150 байхад тухайн үеийн агаарын чанарын индексийн тоон үзүүлэлтийг 150 гэж үнэлж, агаарын чанар бага бохирдолтой гэж үзнэ.

Дөрөв. Агаарын чанарын индексийн мэдээлэл

4.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний байгууллага, мэргэжлийн алба, орон нутаг дахь салбарууд нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр агаарын чанарын индексийн мэдээг холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлэх ба мэдээллийн үнэн бодит байдлыг хариуцна.

4.2. Агаарын чанарын индексийн мэдээг цаг хугацааны хувьд дараах байдлаар мэдээлнэ. Үүнд:

- а) өмнөх өдрийн;
- б) тухайн үеийн;

4.3. Агаарын чанарын индексийн мэдээнд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

- а) Байршил;
- б) Хугацаа (он, сар, өдөр, цаг);
- в) Индексийн хамгийн өндөр үнэлэгдсэн гол бохирдуулах бодисын нэр болон индексийн тоон үзүүлэлт, бусад бохирдуулах бодисын нэр, индексийн тоон үзүүлэлт;

- г) Агаарын чанарын индексийн ангилалд харгалзах агаарын чанарын түвшин, тэмдэглэгээ (өнгөөр)

- д) Эрүүл мэндийн нөлөөлөл, зөвлөгөө

4.4. Агаарын чанарын индексийн мэдээг хураангуй эсвэл дэлгэрэнгүй хэлбэрээр хэвлэл мэдээллийн дараах хэрэгслээр мэдээлнэ. Үүнд:

- а) Сонин;
- б) Телевиз;
- в) Утас;
- г) Интернет;
- д) Бусад



**Агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах
бодисын тодорхойлолт, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл,
эрүүл мэндийн зөвлөгөө**

Нэг. Нийтлэг үндэслэл

Агаар дахь бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэхдээ хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, том болон нарийн ширхэглэгт тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл, озон зэрэг агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодис тус бүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үндэслэн тогтооно.

Хоёр. Агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодисын тодорхойлолт

Хүхрийн давхар исэл (SO₂): Гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүчний ажил хийж байгаа үед хүхрийн давхар исэлд их өртөмтгий байдаг. Гол нөлөө нь амьсгалын замыг нарийсгадаг бөгөөд шуухитнах, амьсгаа давчдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Хүхрийн давхар исэл нь амьсгал цочроосноос найтаах, ханиах зэрэг физиологийн хариу үйлдэл үзүүлэх бөгөөд сөрөг нөлөө зогсоход уушгины үйл ажиллагаа цагийн дотор хэвийн байдалд ордог. Хүхрийн давхар ислийн архаг нөлөө нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээдэг. Зүрх судасны өвчтэй болон уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

Азотын давхар исэл (NO₂): Өнгөгүй, үнэргүй хий бөгөөд агаар мандалд бор шаргал өнгөтэй болдог. Азотын давхар исэл нь уушгины эдийг цочроох ба амьсгалын замын халдварт өртөмтгий байдлыг нэмэгдүүлдэг. Азотын давхар исэл нь амьсгалын замын өвчний тохиолдлыг ихэсгэх, гуурсан хоолойн багтраа болон үрэвсэлтэй хүний мэдрэгшлийг нэмэгдүүлэх, уушгины хамгаалах механизмыг бууруулах, зүрх судасны архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй. Зүрх судасны, уушгины архаг өвчтэй хүмүүс, түүнчлэн хүүхдүүд, өндөр настнууд архаг нөлөөнд өртөмтгий байдаг.

Тоосонцор (PM 2.5; PM 10): Агаарт хатуу, шингэн төлөв байдалтай оршдог. 10 микрометрээс бага хэмжээтэй тоосны богино (1-24 цаг) ба урт хугацааны (хэдэн жилийн) нөлөөлөл нь уушги, зүрхний өвчлөл, нас баралтын нэг хүчин зүйл болдог. Зүрхний эсвэл уушгины өвчтэй хүмүүс, тухайлбал зүрхний архаг өвчтэй хүн, титэм судасны өвчтэй, гуурсан хоолойн багтраа өвчтэй хүн, өндөр настнууд (уушгины эсвэл зүрхний өвчингүй байж болно) тоосонд мэдрэмтгий байдаг. Зүрхний өвчтэй хүн тоосны нөлөөнд өртсөнөөс цээжээр хөндүүрлэх, чичрэх, амьсгал давхцах, сульдах, зүрхний хэмнэл алдагдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.

Тоос нь амьсгалын замын халдварт өвчний өртөмтгий байдлыг ихэсгэх бөгөөд амьсгалын замын архаг өвчнийг сэдрээх нөлөөтэй.

Озон (O₃): Гурван атомт хүчилтөрөгчөөс тогтсон хий төлөв байдалтай нэгдэл. Озон нь атмосферийн дээд давхарга болон газрын гадарга орчмын агаарт байдаг бөгөөд озон хаана байгаагаас шалтгаалж хүний эрүүл мэндэд эерэг, сөрөг нөлөө үзүүлдэг. Атмосферийн агаарын дээд давхаргад оршдог озон нь нарны хэт ягаан туяаны хортой нөлөөнөөс хүн, амьтныг хамгаалах биологийн ач холбогдолтой бол газрын гадарга орчмын атмосферийн агаар дахь озон нь хүний эрүүл мэндэд аюултай. Гадаа биеийн хүчний ажил хийх, зуны улиралд хүүхдүүд гадаа удаан хугацаагаар тоглоход озоны нөлөөлөлд өртөх эрсдэл нэмэгддэг. Амьсгалын замын өвчтэй хүмүүс, тухайлбал гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүсийн уушги озонд маш мэдрэг байдаг тул бусад хүмүүстэй харьцуулахад озоны хэмжээ бага байхад ч харьцангуй хурдан озоны нөлөөнд өртөж, эрүүл мэндэд нь өөрчлөлт гардаг. Озон нь амьсгалын замын салст бүрхэвчийг цочроох, уушгины үйл ажиллагааг бууруулах үйлчилгээтэй тул озоны нөлөөнд өртсөн хүмүүст ханиах, хоолой хорсох, цээжээр хөндүүрлэх, амьсгал авалт хурдасч, өнгөц болох зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Озон нь гуурсан хоолойн багтраа өвчнийг сэдрээдэг бөгөөд ялангуяа гэрийн тэжээмэл амьтан, ургамлын тоос, хачиганд харшилтай хүмүүс озонд их мэдрэмтгий тул ийм хүмүүс гуурсан хоолойн багтраа өвчнөөр өвдөх нь элбэг байдаг. Түүнчлэн амьсгалын замын халдварт өвчинд өртөмтгий байдлыг ихэсгэхэд нөлөөлдөг.

Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO): Өнгөгүй, үнэргүй хий. Түлшин дэх нүүрстөрөгч бүрэн шатаагүй үед үүсдэг. Нүүрстөрөгчийн дутуу исэл уушгиар дамжиж, цусны урсгалд орж, эсэд хүчилтөрөгчийг зөөвөрлөдөг гемоглобинтой нэгдэн “Карбоксигемоглобин” гэдэг нэгдэл үүсгэдэг. Иймээс хүний бие махбодь, эдэд очих хүчилтөрөгчийн хэмжээг багасгадаг. Зүрх судасны өвчтэй хүмүүс, тухайлбал зүрхний бах өвчтэй хүмүүс хамгийн их эрсдэлтэй бөгөөд биеийн хүчний ажил хийж байгаа үед нүүрстөрөгчийн дутуу ислийн нөлөөлөлд өртвөл цээжээр өвдөх болон зүрх судасны бусад шинж тэмдгүүд илэрдэг. Зүрх судас, амьсгалын замын архаг хууч өвчтэй (зүрхний титэм судасны өвчтэй, цус багадалтай, уушигны архаг бөглөрөө өвчтэй) хүмүүс, нярай хүүхдүүд нүүрстөрөгчийн дутуу исэлд илүү өртөмтгий байдаг.

Гурав. Агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үндэслэн эрүүл мэндийн зөвлөгөөг Хүснэгт 2-т заасны дагуу өгнө.

Агаар дахь түгээмэл тархалттай үндсэн бохирдуулах бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, эрүүл мэндийн зөвлөгөө

Хүснэгт 1

АЧИ		Озон	Тоосонцор	Нүүрстөрөгчийн дутуу исэл	Хүхрийн давхар исэл	Азотын давхар исэл
0-50 Цэвэр	Нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй				
	Эрүүл мэндийн зөвлөгөө	Зөвлөгөө шаардлагагүй				
51-100 Хэвийн	Нөлөөлөл	Хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын эмгэг шинж тэмдгүүд илэрч болно	Хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын эмгэг шинж тэмдэг илэрч болох ба зүрх, уушгины өвчтэй болон өндөр настай хүмүүсийн архаг өвчин сэдэрч болно.	Нөлөөлөл байхгүй		
	Эрүүл мэндийн зөвлөгөө	Хэт мэдрэг хүмүүс эрүүл мэнддээ анхаарал тавих нь зүйтэй		Зөвлөгөө шаардлагагүй		
101-250 Бага зэргийн бохирдолтой	Нөлөөлөл	Хүүхдүүд, насанд хүрэгсэд, уушгины өвчтэй, гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүсийн амьсгал давчдах, амьсгалын замын бусад эмгэг шинж тэмдгүүд илрэх магадлал ихэснэ.	Хэт мэдрэг хүмүүсийн амьсгалын замын өвчний шинж тэмдэг ихсэх, зүрх, уушгины архаг өвчтэй болон өндөр настай хүмүүсийн архаг өвчин хүндрэх магадлалтай.	Зүрхний архаг өвчтэй хүмүүст зүрх судасны шинж тэмдэг, тухайлбал цээжээр өвдөх г.м. шинж тэмдэг илэрсний улмаас биеийн хүчний ажил хийх чадвар буурах магадлал ихсэнэ.	Гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдгүүд, тухайлбал цээж давчдах, амьсгалын хэмнэл алдагдах г.м. шинж тэмдэг ихсэх магадлалтай.	
	Эрүүл мэндийн зөвлөгөө	Хүүхдүүд, өндөр настан, уушгины өвчтэй, тухайлбал гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс удаан хугацаанд гадаа тоглохгүй байх, биеийн хүч шаардсан ажлыг гадаа удаан хугацаагаар хийхгүй байх хэрэгтэй.	Зүрх судас, уушгины архаг өвчтэй хүмүүс, хүүхдүүд, өндөр настангууд гадаа биеийн хүчний хүнд ажил хийх, тоглох хугацаагаа багасгах хэрэгтэй.	Зүрх судасны, тухайлбал зүрхний бах өвчтэй хүмүүс биеийн хүч шаардсан ажил хийхээ хязгаарлах, нүүрстөрөгчийн дутуу исэл их хэмжээгээр гаргадаг эх үүсвэр (тухайлбал автозам)-ээс хол байх хэрэгтэй.	Гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс гадаа биеийн хүч шаардсан ажил хийхээ хязгаарлах нь зүйтэй.	
зэргийн бох	Нөлөөлөл	Хүүхдүүд, насанд хүрэгсэд, уушгины өвчтэй,	Зүрх, уушгины архаг өвчинтэй болон өндөр настай	Зүрхний архаг өвчтэй хүмүүст зүрх судасны шинж тэмдэг	Гуурсан хоолойн багтраатай, гуурсан хоолойн	архаг

		<p>тухайлбал гуурсан хоолойн багтраатай хүмүүст амьсгал давчдах, амьсгалын замын бусад эмгэг шинж тэмдгүүд илрэх нь ихсэх ба нийт хүн амын дунд амьсгалын замын эмгэг шинж тэмдэг илрэх магадлалтай.</p>	<p>хүмүүсийн өвчний хүндрэл, нас баралт ихэснэ.</p> <p>Нийт хүн амын дунд амьсгалын замын өвчний шинж тэмдэг ихэснэ.</p>	<p>тухайлбал, цээжээр өвдөх шинж тэмдэг ойрхон давтамжтай илэрсний улмаас биеийн хүчний ажил хийх чадвар буурна.</p>	<p>үрэвсэлтэй хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдгүүд, тухайлбал цээж давчдах, амьсгалын хэмнэл алдагдах, шуухитнах, ханиалгах г.м. шинж тэмдэг ихэснэ. Зүрх судас, уушгины архаг өвчин хүндрэх магадлалтай.</p>
	Эрүүл мэндийн зөвлөгөө	<p>Хүүхдүүд, өндөр настан, амьсгалын замын архаг өвчтэй тухайлбал гуурсан хоолойн багтраатай хүмүүс гадаа удаан хугацаагаар байх, гадаа биеийн хүчний хүнд ажил хийх хугацаагаа багасгах хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтанд байх шаардлагатай.</p>	<p>Зүрх, уушгины архаг өвчтэй болон өндөр настай хүмүүс, хүүхдүүд гадаа удаан хугацаагаар байх болон гадаа биеийн хүчний хүнд ажил хийхээс зайлсхийх, гадаа ажиллах цагаа богиносгох хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах, архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн заавраар эмээ тогтмол хэрэглэх, эмчийн хяналтад байх шаардлагатай.</p>	<p>Зүрхний өвчтэй хүмүүс биеийн хүчний дунд зэргийн ажил хийхээ хязгаарлах, нүүрстөрөгчийн дутуу исэл их хэмжээгээр гаргадаг эх үүсвэр (тухайлбал автозам)-ээс хол байх хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтад байх шаардлагатай.</p>	<p>Хүүхдүүд, гуурсан хоолойн багтраа, зүрх, уушгины өвчтэй хүмүүс гадаа биеийн хүч шаарддаг ажил хийхээ хязгаарлах хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах шаардлагатай.</p>
401-500 Их бохирдолтой	Нөлөөлөл	<p>Хүүхдүүд, насанд хүрэгсэд, уушгины өвчтэй, тухайлбал гуурсан хоолойн багтраатай хүмүүст амьсгал давчдах болон амьсгалын замын хүнд зэргийн шинж тэмдэг илрэх нь ихсэх ба нийт хүн амын дунд амьсгалын замын эмгэг шинж тэмдгүүд ихсэх магадлалтай.</p>	<p>Зүрх, уушгины архаг өвчинтэй болон өндөр настай хүмүүсийн өвчний хүндрэл ихэснэ. Нийт хүн амын дунд амьсгалын замын өвчний шинж тэмдэг мэдэгдэхүйц ихэснэ.</p>	<p>Зүрхний архаг өвчинтэй хүмүүст зүрх судасны шинж тэмдэг тухайлбал цээжээр өвдөх шинж тэмдэг хүчтэй илэрнэ.</p>	<p>Гуурсан хоолойн багтраатай хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэгүүд тухайлбал шуухитнах, амьсгал давчдах, ханиалгах шинж тэмдэг мэдэгдэхүйц ихэснэ. Зүрх, уушгины архаг өвчин сэдэрч хүндэрнэ.</p>
	Эрүүл мэндийн	<p>Хүүхдүүд, насанд хүрэгсэд,</p>	<p>Зүрх, уушгины архаг өвчтэй болон өндөр</p>	<p>Зүрхний тухайлбал бах өвчтэй хүмүүс биеийн</p>	<p>Хүүхдүүд, гуурсан хоолойн багтраа,</p>

	зөвлөгөө	уушгины өвчтэй, тухайлбал гуурсан хоолойн багтраатай хүмүүс гадаа биеийн хүчний ямар ч төрлийн ажил хийхээс зайлсхийх, хүн бүр, ялангуяа хүүхдүүд гадаа биеийн хүч шаардсан ажил хийх хугацаагаа багасгах хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах, архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтад байх шаардлагатай.	настай хүмүүс, хүүхдүүд гадаа биеийн хүчний ямар ч төрлийн ажил хийхээс зайлсхийх хэрэгтэй. Хүн бүр гадаа удаан хугацаагаар байх болон биеийн хүчний хүнд ажил хийхээс зайлсхийх хэрэгтэй.	хүчний ямар ч төрлийн ажил хийхээс зайлсхийх ба нүүрстөрөгчийн дутуу исэл их хэмжээгээр гаргадаг эх үүсвэр (тухайлбал автозам)-ээс хол байх хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтад байх шаардлагатай.	зүрх, уушгины өвчтэй хүмүүс гадаа биеийн хүч шаарддаг ажил хийхээс зайлсхийх, хүн бүр гадаа биеийн хүчний ажил хийх хугацаагаа багасгах хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах шаардлагатай.
	Нөлөөлөл	Хүүхдүүд, насанд хүрэгсэд, уушгины өвчтэй, тухайлбал гуурсан хоолойн багтраатай хүмүүст амьсгал давчдах болон амьсгалын замын өвчний хүнд зэргийн хүндрэлүүд илрэх нь мэдэгдэхүйц ихсэх ба нийт хүн амын дунд амьсгалын замын эмгэг шинж тэмдгүүд ихэснэ.	Зүрх, уушгины архаг өвчинтэй болон өндөр настай хүмүүсийн өвчний хүндрэл маш хүнд зэргээр илэрнэ. Нийт хүн амын дунд амьсгалын замын өвчний аюултай эрсдлүүд тохиолдоно.	Зүрхний архаг өвчтэй хүмүүст зүрх судасны шинж тэмдэг, тухайлбал цээжээр өвдөх шинж тэмдэг маш хүнд зэргээр илрэх ба нийт хүн амын дунд эдгээр шинж тэмдэг ажиглагдаж болно.	Гуурсан хоолойн багтраа, гуурсан хоолойн архаг үрэвсэлтэй хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдгүүд, тухайлбал шуухитнах, амьсгал давчдах, ханиалгах шинж тэмдэг хүчтэй илрэх, зүрх, уушгины өвчний хүндрэл ихэснэ. Нийт хүн амын дунд амьсгалын замын өвчин, түүний шинж тэмдгүүд илэрнэ.
	Эрүүл мэндийн зөвлөгөө	Хүн бүр гадаа биеийн хүч шаардсан ямар ч төрлийн ажил хийхээс зайлсхийх хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтад байж шаардлагатай.	Хүн бүр гадаа биеийн хүч шаардсан ямар ч төрлийн ажил хийхээс зайлсхийх нь зүйтэй. Зүрх, уушгины архаг өвчтэй болон өндөр настай хүмүүс, хүүхдүүд гэртээ байх ёстой ба биеийн хүчний хөнгөн ажил хийх хэрэгтэй. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах,	Зүрхний тухайлбал бах өвчтэй хүмүүс биеийн хүчний ямар ч төрлийн ажил хийхээс зайлсхийх ба нүүрстөрөгчийн дутуу исэл их хэмжээгээр гаргадаг эх үүсвэр (тухайлбал автозам)-ээс хол байх хэрэгтэй. Хүн бүр биеийн хүчний хүнд ажил хийхээ хязгаарлах, цэвэр агаарт салхинд гарах, архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтад байж шаардлагатай.	Хүүхдүүд, гуурсан хоолойн багтраа, зүрх, уушгины өвчтэй хүмүүс гэртээ байх ёстой ба хүн бүр гадаа биеийн хүчний ажил хийхээс зайлсхийх шаардлагатай. Цэвэр агаарт салхинд гарах хэрэгтэй. Архаг хууч өвчтэй хүмүүс даралтаа тогтмол хянах, эмчийн хяналтад байж шаардлагатай.